

Гамшгаас хамгаалах сургалт, дадлага
зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3.2, 13 дугаар зүйлийн 13.1, 16 дугаар зүйл, 32 дугаар зүйлийн 32.1.8, Засгийн газрын 2011 оны 339 дүгээр, 340 дүгээр тогтоол, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2006 оны 44 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт байрлах төр, захиргааны болон аж ахуйн нэгж байгууллагуудад гамшгийн аюулын зарлан мэдээллийн дохиогоор ажиллах сургалт, дадлагыг 2018 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн 16:00 цагт зохион байгуулсугай.

2.Гамшгийн аюулын зарлан мэдээллийн дохиогоор ажиллах сургалт, дадлагыг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу өндөр хэмжээнд зохион байгуулахыг Нийслэлийн Онцгой байдлын газар /Ж.Чүлтэмсүрэн/ болон дүүргийн Засаг дарга нарт, уг үйл ажиллагааг зохион байгуулсан талаарх илтгэх хуудсыг гэрэл зургаар баталгаажуулан, 2018 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн дотор Нийслэлийн Онцгой байдлын газарт хүргүүлэхийг нийслэлийн төр, захиргааны байгууллага, аж ахуйн нэгжийн удирдлагуудад тус тус даалгасугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН
ЗАХИРАГЧ

С.БАТБОЛД